## БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хутаг-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** БУА-2023/131/НА-СА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Булган аймаг
2022 он


Дарга, тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ

Утас: **7034-2580**

Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.**Энхцоодол**

Утас: **7034-2716**

Цахим хаяг: : enkhtsoodolj@**audit.gov.mn**

ЦЭСБ аудит ХХК-ийн захирал: Ч.**Цэрэннадмид**

Утас: **9511-2689**

Цахим хаяг: tsesb.audit@**gmail.com**

**Аудитор Ш.Ганчимэг**

**Утас: 99377360**

**Цахим хаяг: shagdarganchimeg44@jmail.com**


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ..... 3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ..... 5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ..... 14
4. АУДИТЫН ТАЙЛАН ..... 17
4.1 Ерөнхий зүйл..... 17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал..... 17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ..... 17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 18
4.5.1 Завсрын аудитын талаар..... 18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 18
5.1 Төлбөрийн акт..... 19
5.2 Албан шаардлага ..... 19
5.3 Зөвлөмж ..... 19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ..... 21
7. Алдаа, зөрчилтэй асуудлын бүртгэл..... 22

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ДЭМБ | Дэлхийн эрүүл мэндийн байгууллага |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс:7034-2580
E-mail:bulgan@audit.gov.mn

2023.02.21 № 134

танай ________ ны № ________ т

ХУТАГ-ӨНДӨР СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Б.ТУЯАЦЭЦЭГ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хутаг-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Эрүүл мэндийн төвийн 2022 оны үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс 82,019.2 мянга, орон нутгийн тусвөөс төсвөөс 1,259,885.4 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр батлалснаас нийт зардлын гүйцэтгэл 91.4 хувьтай хэрэгжжээ.

Тайлант онд Эрүүл мэндийн даатгалын сангаас авах 237,630.8 мянган төгрөгийн төлбөрт үйлчилгээний авлагыг бүрэн барагдуулсан, худалдаж авсан 205,282.0 мянган төгрөгийн багаж, тоног төхөөрөмж, үнэ төлбөргүй, хандив тусламжаар хүлээн авсан 22,000.0 мянган төгрөгийн автомашин, 184,918.8 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэж, санхүүгийн тайланд толилуулж, тодруулсан байна.

D:/bichighereg/2023A4toot

006020167

**Аудитын гол асуудал**

Тус сургуулийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын даргын 2022 онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөний үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 9 зорилтын хүрээнд 37 арга хэмжээ баталснаас гүйцэтгэлээр 94.0 хувийн биелэлттэй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.ЭРДЭНЭ

D:/bichighereg/2023A4toot

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **407,635,215.85** | **325,265,717.20** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **7,910,540.39** | **123,559,986.11** |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **7,910,540.39** | **123,559,986.11** |
| **3121** | **Төгрөг** | 7,910,540.39 | 123,559,986.11 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 7,910,540.39 | 123,559,986.11 |
| **33** | **АВЛАГА** | **239,352,719.77** | **00.00** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 1,721,919.77 | 00.00 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 237,630,800.00 | 00.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **160,371,955.69** | **201,705,731.09** |
| **351** | **Түүхий эд материал** | 118,174,075.92 | 153,665,710.50 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 2,599,450.00 | 2,599,450.00 |
| 35130 | Эм боох материал | 115,574,625.92 | 151,066,260.50 |
| **354** | **Хангамжийн материал** | **41,122,524.77** | **46,964,665.59** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 537,137.00 | 1,862,570.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 16,318,559.00 | 18,610,239.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 00.00 | 00.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 6,391,188.00 | 7,465,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 122,100.00 | 122,100.00 |
| 35460 | Хүнсний материал | 6,396,291.85 | 7,547,507.67 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 11,357,248.92 | 11,357,248.92 |
| 35500 | Биологийн хөрөнгө | 1,075,355.00 | 1,075,355.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,617,988,882.53** | **1,810,872,080.79** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **1,617,988,882.53** | **1,810,872,080.79** |
| 391 | Газар | 33,566,000.00 | 33,566,000.00 |
| **392** | **Биет хөрөнгө** | **1,583,749,132.53** | **1,776,848,893.29** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,532,824,771.87 | 1,536,324,771.87 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (270,728,200.02) | (298,931,562.66) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 145,724,434.00 | 167,724,434.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (45,080,473.86) | (67,788,714.14) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 375,545,492.29 | 615,891,766.84 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (167,257,762.49) | (195,552,790.31) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 34,569,598.22 | 41,163,598.22 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (22,700,268.91) | (23,894,526.91) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 1,560,000.00 | 2,810,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (708,458.57) | (898,083.62) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **673,750.00** | **457,187.50** |
| 39301 | Програм хангамж | 1,155,000.00 | 1,155,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (481,250.00) | (697,812.50) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,025,624,098.38** | **2,136,137,797.99** |

| | | | |
|---|---|---|---|
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **12,909,813.00** | **00.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 12,909,813.00 | 00.00 |
| **413** | **Өглөг** | 12,909,813.00 | 00.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 12,609,813.00 | 00.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 300,000.00 | 00.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 300,000.00 | 00.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,012,714,285.38** | **2,136,137,797.99** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **2,012,714,285.38** | **2,136,137,797.99** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 743,295,181.25 | 743,295,181.25 |
| 51101 | Өмч: - төрийн | 743,295,181.25 | 743,295,181.25 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **805,187,816.50** | **928,611,329.11** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 805,187,816.50 | 805,187,816.50 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 123,423,512.61 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 464,231,287.63 | 464,231,287.63 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,025,624,098.38** | **2,136,137,797.99** |

*ЦЭСБ аудит ХХК*

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,556,582,151.72** | **1,345,565,161.93** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **269,561,390.72** | **236,875,414.93** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **269,561,390.72** | **236,875,414.93** |
| 120001 | Хувьцааны ногдол ашиг | 60,458,395.01 | - |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | (235,844,165.00) | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | (237,630,800.00) | - |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 1,786,635.00 | - |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө | 8,265,000.00 | 77,894,454.55 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого бараа материал | 436,682,160.71 | 158,980,960.38 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,287,020,761.00** | **1,108,689,747.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **681,777,249.00** | - |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 681,884,400.00 | - |
| 131003 | Төвлөрүүлэх шилжүүлэг | (107,151.00) | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **494,377,968.00** | **4,415,966.00** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 1,372,200.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 478,498,968.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 14,506,800.00 | 4,415,966.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 82,433,100.00 | 82,019,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 82,433,100.00 | 82,019,200.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 28,432,444.00 | 1,022,254,581.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 27,876,294.00 | 1,022,254,581.00 |
| 134003 | Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт | 556,150.00 | - |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,637,933,259.91** | **1,222,141,649.32** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,637,933,259.91** | **1,222,141,649.32** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,536,783,259.91** | **1,221,586,609.32** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **654,447,133.90** | **648,319,177.73** |
| 210101 | Үндсэн цалин | 342,876,492.10 | 374,317,157.44 |
| 210102 | Нэмэгдэл | 255,579,947.80 | 209,532,226.13 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 9,432,000.00 | 6,800,000.00 |
| 210104 | Урамшуулал | 46,558,694.00 | 57,669,794.16 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **90,186,817.66** | **83,163,112.77** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 64,762,509.86 | 59,183,210.08 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,779,713.40 | 6,007,825.41 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,323,242.70 | 4,792,420.39 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,312,694.90 | 1,197,605.02 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,008,656.80 | 11,982,051.87 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **78,845,249.00** | **79,573,560.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,299,649.00 | 9,816,928.00 |
| 210302 | Түлш, халаалт | 63,744,000.00 | 65,955,032.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,801,600.00 | 3,801,600.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **28,782,501.08** | **36,375,845.40** |

| | | | |
|---|---|---|---|
| 210401 | Бичиг хэрэг | 4,267,115.00 | 2,032,717.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 16,645,240.00 | 23,933,655.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,013,017.50 | 1,086,953.40 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 5,066,290.00 | 9,230,520.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 122,763.58 | 92,000.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 668,075.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | **585,582,555.72** | **224,369,305.98** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 556,855,992.87 | 183,671,601.80 |
| 210502 | Хоол, хүнс | 28,726,562.85 | 24,033,704.18 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 16,664,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **7,065,830.00** | **14,379,840.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 397,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | - | 944,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,065,830.00 | 13,038,840.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **1,322,000.00** | **2,100,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,322,000.00 | 2,100,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **10,082,036.00** | **15,583,886.15** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,879,761.00 | 13,323,026.15 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 450,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 133,950.00 | 31,600.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 142,193.00 | 83,860.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 67,000.00 | 60,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 346,500.00 | 1,010,400.00 |
| 210807 | Газрын төлбөр | 62,632.00 | - |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | - | 1,075,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **80,469,136.55** | **117,721,881.29** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,086,668.00 | 36,914,805.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 79,382,468.55 | 80,807,076.29 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **101,150,000.00** | **555,040.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 101,150,000.00 | - |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 52,200,000.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 48,950,000.00 | - |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 555,040.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 555,040.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(81,351,108.19)** | **123,423,512.61** |
| **145** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | - | - |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 97,624,307.56 | - |
| 225007 | Хөрөнгийн дахин үнэлгээний зардал | 97,624,307.56 | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (97,624,307.56) | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(178,975,415.75)** | **123,423,512.61** |

*ЦЭСБ аудит ХХК*

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,287,020,761.00** | **1,346,320,547.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,287,020,761.00** | **1,346,320,547.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **681,777,249.00** | **00.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 681,884,400.00 | 00.00 |
| 131003 | Төвлөрүүлэх шилжүүлэг | (107,151.00) | 00.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **494,377,968.00** | **4,415,966.00** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 1,372,200.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 478,498,968.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 14,506,800.00 | 4,415,966.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **82,433,100.00** | **82,019,200.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 82,433,100.00 | 82,019,200.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | **28,432,444.00** | **1,259,885,381.00** |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 27,876,294.00 | 1,259,885,381.00 |
| 134003 | Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт | 556,150.00 | 00.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,277,106,220.61** | **1,041,029,281.28** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,277,106,220.61** | **1,041,029,281.28** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,175,956,220.61** | **1,040,474,241.28** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **652,519,011.11** | **648,319,177.73** |
| 210101 | Үндсэн цалин | 331,908,168.00 | 374,317,157.44 |
| 210102 | Нэмэгдэл | 264,620,149.11 | 209,532,226.13 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 9,432,000.00 | 6,800,000.00 |
| 210104 | Урамшуулал | 46,558,694.00 | 57,669,794.16 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **90,859,118.00** | **81,441,193.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 63,400,387.52 | 57,461,290.31 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,569,966.85 | 6,007,825.41 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,186,585.47 | 4,792,420.39 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,282,827.66 | 1,197,605.02 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,419,350.50 | 11,982,051.87 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **78,685,249.00** | **79,502,560.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,702,282.00 | 9,816,928.00 |
| 210302 | Түлш, халаалт | 64,181,367.00 | 65,884,032.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,801,600.00 | 3,801,600.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **31,418,843.50** | **39,158,870.40** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,736,800.00 | 3,090,150.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 21,681,428.00 | 25,072,467.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,781,417.50 | 1,342,953.40 |

| | | | |
|---|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 4,219,400.00 | 4,024,900.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,999,798.00 | 5,628,400.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **234,737,748.00** | **155,635,889.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 200,823,248.00 | 107,459,589.00 |
| 210502 | Хоол, хүнс | 32,354,500.00 | 25,446,300.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,560,000.00 | 22,730,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **70,615,100.00** | **13,543,540.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 57,868,000.00 | 00.00 |
| 210602 | Тавилга | 00.00 | 6,154,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 00.00 | 1,426,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 12,747,100.00 | 5,963,540.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,322,000.00 | 2,100,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,322,000.00 | 2,100,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **10,199,366.00** | **16,532,886.15** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,946,359.00 | 13,323,026.15 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 450,000.00 | 00.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 133,950.00 | 31,600.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 192,925.00 | 83,860.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 67,000.00 | 60,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 346,500.00 | 1,034,400.00 |
| 210807 | Газрын төлбөр | 62,632.00 | 00.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 00.00 | 2,000,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **5,599,785.00** | **4,240,125.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,599,785.00 | 4,240,125.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **101,150,000.00** | **555,040.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **101,150,000.00** | **00.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 52,200,000.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 48,950,000.00 | 00.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 00.00 | 555,040.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 555,040.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **9,914,540.39** | **305,291,265.72** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **4** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)** | **00.00** | **00.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **00.00** | **189,641,820.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **00.00** | **189,641,820.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 00.00 | 189,641,820.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 00.00 | 189,641,820.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **00.00** | **(189,641,820.00)** |
| **8** | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 9,914,540.39 | 115,649,445.72 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **00.00** | **7,910,540.39** |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **7,910,540.39** | **123,559,986.11** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **00.00** | **00.00** | **00.00** | 00.00 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **743,295,181.25** | **464,231,287.63** | **805,187,816.50** | **2,012,714,285.38** |
| D01 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **743,295,181.25** | **464,231,287.63** | **805,187,816.50** | **2,012,714,285.38** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **743,295,181.25** | **464,231,287.63** | **805,187,816.50** | **2,012,714,285.38** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | **123,423,512.61** | **123,423,512.61** |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **743,295,181.25** | **464,231,287.63** | **928,611,329.11** | **2,136,137,797.99** |

*ЦЭСБ аудит ХХК*

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,226,165,700.00** | **1,040,474,241.28** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,226,165,700.00** | **1,040,474,241.28** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,216,165,700.00** | **1,040,474,241.28** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **728,264,000.00** | **648,319,177.73** |
| 210101 | Үндсэн цалин | 430,170,200.00 | 374,317,157.44 |
| 210102 | Нэмэгдэл | 249,872,300.00 | 209,532,226.13 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 8,946,000.00 | 6,800,000.00 |
| 210104 | Урамшуулал | 29,275,500.00 | 57,669,794.16 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 10,000,000.00 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **89,783,100.00** | **81,441,193.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 62,812,500.00 | 57,461,290.31 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,742,700.00 | 6,007,825.41 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,394,100.00 | 4,792,420.39 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,348,600.00 | 1,197,605.02 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 13,485,200.00 | 11,982,051.87 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **6,000,000.00** | **79,502,560.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 00.00 | 9,816,928.00 |
| 210302 | Түлш, халаалт | 6,000,000.00 | 65,884,032.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 00.00 | 3,801,600.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **40,906,000.00** | **39,158,870.40** |
| 210401 | Бичиг хэрэг | 3,334,000.00 | 3,090,150.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 25,079,200.00 | 25,072,467.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,800,000.00 | 1,342,953.40 |
| 210404 | Ном, хэвлэл | 00.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,666,800.00 | 5,628,400.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **130,026,800.00** | **155,635,889.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 86,793,600.00 | 107,459,589.00 |
| 210502 | Хоол, хүнс | 25,500,000.00 | 25,446,300.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 17,733,200.00 | 22,730,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **195,559,900.00** | **13,543,540.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 186,643,200.00 | 00.00 |
| 210602 | Тавилга | 6,000,000.00 | 6,154,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,666,700.00 | 1,426,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,250,000.00 | 5,963,540.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **2,199,600.00** | **2,100,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,199,600.00 | 2,100,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **14,684,800.00** | **16,532,886.15** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 10,000,000.00 | 13,323,026.15 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 900,000.00 | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 158,400.00 | 31,600.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 84,000.00 | 83,860.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 67,200.00 | 60,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,350,000.00 | 1,034,400.00 |
| 210807 | Газрын төлбөр | 94,800.00 | 00.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 30,400.00 | 00.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 2,000,000.00 | 2,000,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **8,741,500.00** | **4,240,125.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,741,500.00 | 4,240,125.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 10,000,000.00 | 0.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 10,000,000.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 10,000,000.00 | 00.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **00.00** | **189,641,820.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 00.00 | **189,641,820.00** |
| 222001 | Тоног төхөөрөмж | 00.00 | **189,641,820.00** |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 372,048,000.00 | **1,344,920,547.00** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 00.00 | **82,019,200.00** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 00.00 | 82,019,200.00 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,231,339,200.00 | **1,259,885,381.00** |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 1,231,339,200.00 | 1,259,885,381.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | **7,910,540.39** |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | **123,559,986.11** |

*ЦЭСБ аудит ХХК*

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хутаг-Өндөр сумын Эрүүл мэндийн төв нь эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлдэг төрийн байгууллага бөгөөд тайлант онд “Ээлтэй орчин, чанартай үйлчилгээ” гэсэн зорилго дэвшүүлэн сумын иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж ажиллажээ. Тус эрүүл мэндийн төв нь амбулатори, стационари, багийн эмнэлгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж лаборатори, сургалт, сурталчилгаа болон хүүхэд, уламжлалт, эмэгтэйчүүд, нүүр амны чиглэлээр нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг үзүүлж байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд Төрийн хэмнэлтийн тухай хууль шинээр батлагдан хэрэгжсэн, Хөдөлмөрийн тухай хууль шинэчлэгдсэн, мөн Төрийн албаны тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулиудад нэмэлт өөрчлөлтүүд орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй бага гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагатай гэж үзсэн.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хутаг-Өндөр сумын Эрүүл мэндийн төв нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хутаг-Өндөр сумын Эрүүл мэндийн төв 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 110,513.7 мянган төгрөгөөр буюу 5.5 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 7,910.5 | 123,560.0 | 115,649.5 |
| Авлага | 239,352.7 | - | (239,352.7) |
| Бараа материал | 160,372.0 | 201,705.7 | 41,333.7 |
| Үндсэн хөрөнгө | 1,617,988.9 | 1,810,872.1 | 192,883.2 |
| **Нийт хөрөнгө** | **2,025,624.1** | **2,136,137.8** | **110,513.7** |
| Өр төлбөр | 12,909.8 | | (12,909.8) |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 2,012,714.3 | 2,136,137.8 | 123,423.5 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **2,025,624.1** | **2,136,137.8** | **110,513.7** |

Тайлант онд мөнгөн хөрөнгийн дансанд 1,354,231.1 мянган төгрөгийн орлого орж, 1,230,671.1 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд бие даасан байдалд бүрэн шилжсэнтэй холбоотойгоор зарцуулаагүй 123,560.0 мянган төгрөг дансанд үлдсэн байна.

Авлага буурсан нь өнгөрсөн оны ЭМД-ын сангаас гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн үлдэгдэл 239,352.7 мянган төгрөг орж ирсэнтэй холбоотой байна.

Бараа, материал дансны үлдэгдэл 41,333.7 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 213,254.8 мянга, хандив, тусламжаар 145,104.3 мянга, аймгийн Эрүүл мэндийн газраас 2,135.8 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл үнэ төлбөргүй хүлээн авч, өмнөх онд ковидын шинжилгээний төлбөрийн орлогоос худалдаж авсан 1,600.0 мянган төгрөгийн материалыг орлогод бүртгэж, 1,582.7 мянган төгрөгийн материалыг акталж, үйл ажиллагаанд 319,178.5 мянган төгрөгийн материалыг зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны хувьд төсвийн хөрөнгөөр 195,795.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл худалдан авсан, ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар 15,640.0 мянга, аймгийн Эрүүл мэндийн газраас 3,964.5 мянга, “Мед буян” ХХК-аас 31,100.0 мянган төгрөгийн компьютер, сумын ЗДТГ-аас 22,000.0 мянган төгрөгийн “Toyota prius” маркийн автомашин тус тус үнэ төлбөргүй хүлээн авчээ. Мөн сум хөгжүүлэх сангийн 4,750.0 мянган төгрөгийн хөрөнгөөр хийгдсэн барилгын засварыг капиталжуулж, өмнөх оны ковидын шинжилгээний төлбөрөөс худалдан авсан 440.0 мянган төгрөгийн угаалгын машиныг бүртгэж, тайлант хугацаанд 80,807.1 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан зэргээс шалтгаалж 192,883.2 мянган төгрөгөөр өссөн байна.

## 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагч 2022 оны төсвийн төсөлд нийт зарлагыг 1,341,904.6 мянган төгрөгөөр тооцож, санхүүжих эх үүсвэрийг улсын төсвөөс /ОН/ 82,019.2 мянга, ЭМД-ын сангаас 1,259,885.4 мянган төгрөгөөр тус тус бүрдүүлэхээр төлөвлөн дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант онд бие даасан байдалд бүрэн шилжиж Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т "Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн үзүүлэх Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1-д заасан тусламж, үйлчилгээний зардлыг тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар тооцож, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлнэ" гэж заасны дагуу шинэ тогтолцоонд шилжин гүйцэтгэлээр ЭМД-ын сангаас санхүүжиж эхэлсэнтэй холбоотой санхүүжилтийн зарцуулах эрхийг дээд шатны төсвийн захирагч нь тухай бүр эдийн засгийн ангиллаар баталж эхэлжээ.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр ЭМД-ын сангаас 1,259,885.4 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 4,416.0 мянга, орон нутгийн төсвөөс 82,019.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,040,474.2 мянга, хөрөнгийн зардалд 189,641.8 мянган төгрөгийг зарцуулж, орон нутагт 555.0 мянган төгрөг төвлөрүүлж, зарцуулаагүй 123,560.0 мянган төгрөгийг үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,230,116. мянган төгрөг буюу 91.3 хувьтай байгаа нь гүйцэтгэлээр авсан санхүүжилтээс цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 89,050.0 мянга, нормативт зардлыг 6,443.6 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал 3,001.9 мянга, зэрэг зардлыг тус тус зарцуулаагүй нь тухайн жилийн зарцуулаагүй үлдэгдлийг дараа онд зарцуулах эрх үүссэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Хөтөлбөр - 71602 | 1,231,339.2 | 1,261,448.5 | 30,109.3 | 102,38 |
| 2 | Арга хэмжээ 80302 | 344,634,3 | 345,972,3 | 1,338.0 | 100,3 |
| 3 | Арга хэмжээ 81602 | 514,437,9 | 543,209,2 | 28,771.3 | 105,29 |
| 4 | Арга хэмжээ 83603 | 372,267,0 | 372,267,0 | 0,0 | 100 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар орлого төвлөрүүлж, зарцуулаагүй.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “ЦЭСБ аудит” ХХК-ийн аудитор Ш.Ганчимэг, аудиторын туслах Б.Гантуяа нар гүйцэтгэж, хяналтыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Хутаг-Өндөр сумын ЭМТ нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 09 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн орлогын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын дүн 1,666,675.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 16,666.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор гүйцэтгэлээр авсан санхүүжилтээс цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, нормативт зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ зэрэг зардлаас 123,560.0 мянган төгрөг үлдсэн нь тухайн жилийн зарцуулаагүй үлдэгдлийг дараа онд зарцуулах эрх үүссэнтэй холбоотой байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой алдаа, зөрчил илрээгүй болно.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хутаг-Өндөр сумын ЭМТ нь 2022 онд шилэн дансны нэгдсэн системд мэдээлэх цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 21,700.7 мянган төгрөг, зарлагын 1,543,886.5 мянган төгрөг, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний 70,252.4 мянган төгрөгийн хөрөнгө зарцуулах 7 шийдвэрийг мэдээлсэн байна.

Өмнөх аудитаар өгсөн холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргаж, "Шилэн дансны цахим хуудас"-т бүтэн жилээр мэдээлэх аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, худалдан авах ажиллагааны тайлан, сар бүр мэдээлэх батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт байршуулах гэсэн 3 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

*Шийдвэрлэсэн нь*:

Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллах, алдааг давтан гаргасан тул хэрэгжүүлж ажиллах тухай албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 22,184.9 мянган төгрөгийн зөрчил илэрснээс үр дүнгийн урамшуулал, тэтгэмжтэй холбоотой 15,540.3 мянган төгрөгийн 3 акт, 6,047.2 мянган төгрөгийн 2 албан шаардлага, хэрэгжүүлж ажиллах 597.4 мянган төгрөгийн 2 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, Шилэн дансны хуулийн дагуу цаг хугацаанд нь мэдээлж байх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 3 | 15,540.3 | 3 | 15,540.3 | 100.0 |
| Албан шаардлага | 2 | 6,047.2 | 2 | 6,047.2 | 100.0 |
| Зөвлөмж | 3 | 597.4 | 2 | 597.4 | 66.7 |
| **Нийт дүн** | **8** | **22,184.9** | **7** | **22,184.9** | **88.9** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар эм, эмнэлгийн хэрэгслэлийн зарцуулалтыг шалгах асуудалд оруулах нь зүйтэй гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,273.7 мянган төгрөгийн 2 зөрчил[1] илэрснээс, 3,273.7 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчилд албан шаардлага өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

Эрүүл мэндийн төвийн ажилтанд улирлын ажлын үр дүнг үндэслэн олгох мөнгөн урамшууллыг ээлжийн амралттай байх хугацаанд олгосон нь Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын хавсралтын 3.2-т *"Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг үндэслэн үндсэн цалингийн 10-20 хувиар сар бүр тооцож, улирал тутам олгоно”,* 3.4-т *“Мөнгөн урамшуулал олгоход дараахь шалгуур үзүүлэлтийг баримтална”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн тул төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

Өмнөх аудитаар өгсөн холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, тайлант онд давтан гаргаж, “Шилэн дансны цахим хуудас”-т 3 мэдээллийг хугацаа хоцроосон нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.3 дахь “Тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх” гэсэн заалтыг зөрчсөн, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлэв.

Дээрх акт, албан шаардлагын биелэлтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | Үүнээс | | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | Үүнээс | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Төлбөрийн акт | Албан шаардлага | Зөвлөмж | Хариуцлага тооцуулах албан шаардлага | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Улирлын үр дүнгийн урамшууллыг ээлжийн амралттай байх хугацаанд олгосон. | 1 | 3,273.7 | 1 | 3,273.7 | | | | | | | | |
| Дүн | 1 | 3,273.7 | | 3,273.7 | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны цахим хуудаст 3 мэдээллийг хугацаа хоцроосон | 1 | 0.0 | - | - | 1 | 0.0 | | |
| Дүн | 1 | 0.0 | | | 1 | 0.0 | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | - | - | - | - | - | - | - | - |

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны нэмэгдэл хөлсийг 8 албан хаагчид үндэслэлгүй олгосон | 1 | 6,981.8 | 1 | 6,981.8 | - | - | - | - | - | - | - | - |
| Илүү цагийг бүртгэж, баталгаажуулахдаа анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллаагүй | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - | - | - |
| **Дүн** | **2** | **6,981.8** | **1** | **6,981.8** | **-** | **-** | **1** | **-** | | | | |